

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ХОРИН ГУРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны зургаадугаар сарын 25-ний 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 25 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 20 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 1. Дамбын Ганхягийг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх 2. Нөөцөд бүртгэгдсэн иргэн Дамбын Ганхуягийг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын албаны Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын албаны Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай асуудлыг хойшлуулахаар шийдвэрлэв.
3	Эрчим хүчний яамны Төрийн	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар

	<p>захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Наваантаяын Бат-Эрдэнийг Эрчим хүчний яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогтод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Хэнтий аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 06 дугаар сарын 05-16-ны өдрүүдэд Өвөрхангай аймаг, Булган аймаг, Хөвсгөл аймаг, Хэнтий аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Өвөрхангай аймаг, Булган аймаг, Хөвсгөл аймаг, Хэнтий аймагт 2015 оны 06 дугаар сарын 05-16-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 140 иргэн /Өвөрхангай аймагт 20, Булган аймагт 49, Хөвсгөл аймагт 4, Хэнтий аймагт 67/-ийг “Дэс</p>

		<p>түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 5, 6, 7, 8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 40 иргэн /Өвөрхангай аймагт 9, Булган аймагт 5, Хөвсгөл аймагт 5, Хэнтий аймагт 21/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 9, 10, 11, 12 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 35 иргэн /Өвөрхангай аймагт 11, Булган аймагт 14, Хөвсгөл аймагт 1, Хэнтий аймагт 9/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 13, 14, 15, 16 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 26 иргэн /Өвөрхангай аймагт 8, Булган аймагт 4, Хөвсгөл аймагт 4, Хэнтий аймагт 10/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 9-16 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 61 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөл /Ц.Ганболд/-д, Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөл /Л.Батболд/-д, Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөл /Г.Төмөрбаатар/-д, Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөл /М.Болд/-д тус тус</p>
--	--	--

		<p>үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	<p>Төрийн албаны зөвлөлийн Гадаад хэргийн яам, Сангийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг"-ийг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын "нэг"-ийн 2-т "...Гадаад харилцааны яамны дэргэдэх" гэснийг " Гадаад хэргийн яамны дэргэдэх" гэж өөрчилж, бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн батлах.</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн нарийн бичгийн дарга 2. Төрийн захиргааны удирдлагын газрын захирал, 3. Хөрш орнуудын газрын захирал, 4. Ази, Ойрхи Дорнод, Африкийн газрын захирал, 5. Европ, Америкийн газрын захирал, 6. Олон талт хамтын ажиллагааны газрын захирал, 7. Олон улсын эрх зүйн газрын захирал, 8. Консулын газрын захирал, 9. Төрийн захиргааны удирдлагын газрын дэд захирал /Нарийн бичгийн дарга/ тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. <p>Улсын Их Хурлын 2009 оны 87</p>

		<p>дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”-ийг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын “нэг”-ийн 3-т Төрийн албаны зөвлөлийн Сангийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар өөрчлөн батлах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн нарийн бичгийн дарга; 2. Төрийн захиргааны удирдлагын газрын дарга; 3. Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга,; 4. Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газрын дарга; 5. Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газрын дарга; 6. Төрийн сангийн газрын дарга; 7. Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн <p>тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	Төрийн албаны зөвлөлийн Гадаад хэргийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2015 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 02/3315 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны

		<p>шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Гадаад хэргийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус яамны төрийн захиргааны удирдлагын газрын дэд захирал Сэсээрийн Золжаргалыг 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн томилох</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын “нэг”-ийн 5-д “..Төрийн захиргааны удирдлагын газрын зөвлөх Б.Чинүүхэй” гэснийг “...Төрийн захиргааны удирдлагын газрын дэд захирал Сэсээрийн Золжаргал” гэж өөрчлөх</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Золжаргалд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
7	Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгасан Ажлын хэсгийн дүнг танилцуулах	Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгасан Ажлын хэсгийн дүнг хэлэлцэхийг хойшлуулахаар шийдвэрлэв.